

2003 оны мөнгө санхүүгийн бодлогын үр дүн

Тайлант онд мөнгө, санхүүгийн бодлогын үр дүнд санхүүгийн салбарын тогтвортой байдал бэхжиж, санхүүгийн зуучлал улам эрчимжлээ. Түүнчлэн бараа үйлчилгээний үнэ ханш харьцангуй тогтвортой байгаа нь эдийн засгийн өсөлтөнд эерэг нөлөө үзүүлж байна.

Хэрэглээний барааны үнээр илэрхийлэгдсэн инфляци нь 2003 оны эцэст жилийн 4.7 хувьд хүрч Төрөөс 2003 онд баримтлах мөнгөний бодлогод заасан зорилт хангагджээ. Хэрэглээний барааны үнийн индекст өндөр хувийн жин эзэлдэг хүнсний барааны (46.6 %) бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 7.7 хувиар нэмэгдсэн нь инфляцид гол нөлөө үзүүлэв.

Манай улс валютын ханшийн уян хатан бодлого явуулдаг бөгөөд төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкнаас зарласан банк хоорондын ханш өмнөх онтой харьцуулахад 3.8 хувь, евротой харьцах ханш 24.9 хувь, иентэй харьцах ханш 16.4 хувь, юантай харьцах ханш 3.8 хувь, рубльтэй харьцах ханш 12.7 хувиар тус тус суларсан байна.

Банкуудад байршуулсан аж ахуйн нэгж, иргэдийн хадгаламж өмнөх оныхоос 73.7 хувиар өсч 290.5 тэрбум төгрөг, зээл 91.0 хувиар өсч 442.1 тэрбум төгрөг болов. Эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд хурдасч 2001 онд 1.0 хувь байсан бол 2002 онд 4.0 хувь, 2003 онд урьдчилсан байдлаар 5.3 хувьд хүрлээ.

Чанаргүй зээл өмнөх оноос 21.1 тэрбум төгрөгөөр өсч 36.7 тэрбум төгрөг болсон нь нийт зээлийн үлдэгдлийн 8.3 хувийг эзэлж байна. Энэ нь өнгөрсөн оноос 1.1 нэгжээр, 2001 оноос 0.2 нэгжээр өссөн бол 2000 оноос 15.6 нэгжээр буурсан байна.

Зээлийн хүү харьцангуй өндөр байгаа ч аажмаар буурах хандлага ажиглагдаж байна. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оныхоос 1.9

нэгжээр буурч 31.5 хувь, валютынх 0.2 нэгжээр буурч 19.6 хувь болжээ.

Банкнаас гадуурхи мөнгөний нийт мөнгөнд (M2) эзлэх хувь хамгийн өндөр түвшиндээ (39.6%) 1999 онд хүрснээ буурах хандлага ажиглагдаж энэ үзүүлэлт 2003 онд 18.7 хувь болсон нь 2000 оныхоос 20.3, 2001 оныхоос 7.0 нэгжээр буурчээ.

Ийнхүү банк санхүүгийн салбарт гарч байгаа нааштай өөрчлөлтүүд нь нэг талаас иргэд, байгууллагуудын банкны тогтолцоонд илүү итгэлтэй хандах болсон болон банкуудын нэвтрүүлж байгаа төлбөр тооцооны хэлбэрүүдийн хөгжилтэй холбоотой юм. Нөгөө талаас банкуудын эрх зүйн орчин сайжирч банкуудын үйл ажиллагаа жигдэрч байгаагийн илрэл болж байна.

Азийн хөгжлийн банк (АХБ)-наас Монгол улсын хүн амын орон сууцны эрэлт хэрэгцээг хангахад туслах, бага болон дунд орлоготой өрхүүдэд тэдгээрийн орон сууцны төлбөрийн чадавхид нийцсэн орон сууцны зээл олгож амьдрах орчинг сайжруулах, гэр хорооллын дэд бүтэц, үйлчилгээг сайжруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх төслийг өнгөрсөн оноос хэрэгжүүлж эхэлжээ. Уг төслийн зээл Голомт, Зоос, Монгол шуудан, Хадгаламжийн банкуудаар дамжуулан олгогдож байна.

АХБ-ны "Ажлын байр нэмэгдүүлэх", "Хөдөө аж ахуйг хөгжүүлэх", Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Засгийн газрын "Жижиг , дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх" төслийн зээлүүдийг Монголбанкаар дамжуулан зарим банкуудад олгогдож, төсөл амжилттай хэрэгжиж байна.

Тайлант онд Чингис хаан банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) банкны үйл ажиллагаа явуулах эрх авсан нь банкуудын активыг өсгөхөд тодорхой нөлөө үзүүлэв. Банкуудын актив 2002 оноос 67.6 хувиар өсч, 826.1 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ1-ний 60.6 хувьтай тэнцэж байна.

Банкуудын санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, удирдлага зохион байгуулалтыг

сайжруулах зорилгоор Монголбанкнаас банкуудын дүрмийн санг 2004 оны 1 дүгээр улиралд 4 тэрбум төгрөгт хүргэх шийдвэр гаргасан билээ. Тус шийдвэрийг өнгөрсөн онд үйл ажиллагаа явуулж байгаа 17 банкнаас 9 банк биелүүлсэн бөгөөд банкуудын өөрийн хөрөнгө 49.1 тэрбум төгрөгөөр өсчээ.

Мөнгө санхүүгийн салбарт мөнгөний нийлүүлэлт хурдацтай өссөн нь санхүүгийн зуучлалын үр нөлөө юм. Санхүүгийн зуучлалыг илтгэх гол үзүүлэлт болох нийт мөнгө буюу М2/ДНБ-ний харьцаа 2000 онд 24.8 хувь, 2001 онд 29.3 хувь, 2002 онд 37.9 хувь, 2003 онд 51.61 хувьд хүрлээ.

Эдийн засаг дахь мөнгөний зохистой харьцааг Монголбанк удирдан зохицуулахдаа гол төлөв нөөц мөнгөний 2 хэмжээг Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаагаар зохицуулж ирлээ. Монголбанк 2003 онд 1.3 триллион төгрөгийн ТБҮЦ гаргасан бөгөөд 1.0 триллион төгрөгийн ТБҮЦ борлогдсон байна. 2003 онд ТБҮЦ-ны хүүнд Монголбанк 4.6 тэрбум төгрөг төлжээ. 2003 онд банкууд өдөрт дунджаар 42.4 тэрбум төгрөгийн үнэт цаас эзэмшиж байв. Тайлант онд банкууд хоорондоо нийт 347.0 тэрбум төгрөгийн зээл, ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа хийсэн бөгөөд түүний жилийн жигнэсэн дундаж хүү 10.0 хувь байв. Үүнээс репо нөхцөлтэй банк хоорондын санхүүжилт нь 205.5 тэрбум төгрөг байгаа нь өнгөрсөн оноос нэвтрүүлсэн репо нөхцөлтэй арилжаа амжилттай явагдаж байгааг илтгэж байна.

Монголбанк банк болон ББСБ-уудад тавих хяналт шалгалтаа улам боловсронгуй болгох үүднээс хяналт шалгалтын газарт ББСБ-ын хэлтсийг шинээр байгуулан ажиллаж байна.

Тайлант онд 5 ББСБ татан буугдсан бол шинээр 29 ББСБ байгуулагдаж, нийт 88 ББСБ үйл ажиллагаагаа явуулж байна. ББСБ-уудын нийт зээл 2003 оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 95.5 хувиар өсч 60.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Сүүлийн жилүүдийн банкны салбарын өмч хувьчлалын үр дүнд олон улсын банкны менежмент Монголын банкны салбарт нэвтэрч эхэллээ. Төрийн өмчийн ХААН

банкийг өнгөрсөн онд Японы "Эйч Эс" (HS securities) компанид 6 сая 850 мянган ам. доллараар хувьчилла. Тус компани нь ХААН банкны өмнө ажиллаж байсан АНУ-ын "DAI" группын менежментийн багийн гэрээг сунган ажиллаж байгаа бөгөөд 13 сая ам. долларын хөрөнгө оруулахаар болжээ. Мөн Худалдаа хөгжлийн банк Нидерландын "Ай Эн Жи" (ING) банктэй менежментийн тал дээр хамтран ажиллах гэрээг 2003 онд хийж, үйл ажиллагаагаа явуулж байна.

Монголын даатгалын салбарын 90 орчим хувийг эзэлдэг Монгол даатгал компанийг өнгөрсөн онд Оросын Ангара Даатгал, Монголын Чингис хаан банкны хамтарсан "Ангара-СКВ" консерциумд 5 сая 800 мянган ам. доллараар хувьчилсан нь Монголын санхүүгийн салбарт гарсан нэгэн том өөрчлөлтийн нэг боллоо.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд 2003 онд өөрчлөлт оруулж, Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих бие даасан хяналтын зөвлөлийг бий болгов.

Монголбанк Зүүн Өмнөд Азийн орнуудын Төв банкуудын Холбоо (SEASEN), АНУ-ын Холбооны Нөөцийн банк, Дэлхийн банктэй хамтран Ази Номхон Далайн орнуудын Төв банкны хянан шалгагч нарын IV семинарыг 2003 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулав. Сургалт семинарт Индонез, БНСУ, Сингапур, Тайланд зэрэг 11 орны Төв банкны хяналт шалгалтын бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход чухал үүрэгтэй Төв банкуудын хяналт шалгалтын газруудын 23 ахлах хянан шалгагч оролцож, банкны эрсдэлийн удирдлагын арга барилыг дээшлүүлэх, банкны хяналт шалгалтын ур чадварыг өндөржүүлэх асуудлуудыг хэлэлцсэн байна.

МОНГОЛБАНК